

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ

**Стандарт 10. Багшлах
бүрэлдэхүүний заах аргын
чадамжийг сайжруулах**



CDIO –г хэрэгжүүлэхээс өмнөх үйл ажиллагаа

- Багш нарын зааж сургах чадамжийг нэмэгдүүлэх програм эсвэл практик дадлага байхгүй байсан.

CDIO- г хэрэгжүүлэх үеийн үйл ажиллагаа

- МехТС-ийн багш нарт, ялангуяа Хөтөлбөрийн багш нартаа зориулж техникийн ухааны доктор (Ph.D) Ц.Баярсайхан “PLC удирдлага, түүний ажиллах зарчим, хэрэглээ”, магистр Б.Дондогжамц “Ардыюно, түүний бүтэц, зохион байгуулалт” 24 цагийн хичээлийг тус тус зохион байгуулжээ. Мөн магистр М.Дэлгэрнасан “MIT-ийн сургалтын арга зүй”, МХТС-ийн профессор, доктор (Ph.D) Эрдэнэхүү “Хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөмж” зэрэг хичээлийг зохион байгуулжээ. Үүнд, 2016-10-15 өдөр 10-15 цагийн хооронд Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн багш нар 205 тоот өрөөнд цуглаж Идэвхтэй сургалтын арга семинар хийлээ. Семинараар ҮА- хөтөлбөрөөр курс бүрт оюутнуудын гүйцэтгэх зохион бүтээх хичээлийн Төслийн сэдвүүдийг 1-4 дамжаанд хичээл заах багш нар хэлэлцэж тогтлоо.
- 2016-10-18 нд Мехатроникийн лаб.-д Профессорын семинараар ҮА-ын секторын Ц.Баярсайхан, О.Болор, Ж.Давааням, Э.Наранбаатар, Б.Баярсайхан, мөн П.Чойсүрэн нарт Н.Энхтунгалаг багш CDIO хөтөлбөр боловсруулах талаар 14.40-16.10 хүртэл зөвлөмж өглөө. Үргэлжлүүлээд, 17.30-21.00 цаг хүртэл ҮА-ын хөтөлбөрөөр оюутнуудад олгох мэдлэг чадвар, CDIO ур чадварын анхны хувилбарыг гаргалаа.
- 2016-10-29 өдөр CDIO хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг семинар хийлээ. МХТС-ийн профессор Н.Эрдэнэхүү төслийн зохицуулагч Хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн талаар зөвлөмж өглөө.
- 2016 оны 12 дугаар сарын 13-нд МехТС, МХТС, ҮТС-ийн хамтарсан CDIO хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцлоо.

Цаашид хийгдэх ажил

- Багшлах бие бүрэлдэхүүний CDIO чадамжийг сайжруулах ажлыг цаашид үргэлжлүүлнэ.

Голлох үр өгөөж, үр дүн

- Багш нарын зааж сургах чадамжинд анализ хийсэн, судалгаа явуулсан.
- Б.Дондогжамц багш заах арга зүйн чиглэлээр 2017 оны ШУТИС-ийн Тэргүүний багшаар шалгарсан.

Хэрэгжүүлэх явцад илэрсэн давуу болон сул тал

- МехТС-ийн сургуулийн Чанарын зорилт- Манлайлагчдыг бэлтгэн гаргана гэдгээ ухамсарласан.



Үйл ажиллагааны нотолгоо